

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын .... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### **1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин болон цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### **2 дугаар зүйл. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох хууль тогтоомж**

2.1. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3. Энхийг дэмжих ажиллагаан дахь Монгол Улсын оролцоо нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад чиглэсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн шийдвэр, хоёр талын болон олон улсын гэрээтэй зөрчилдөхгүй байна.

##### **3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “энхийг дэмжих ажиллагаа” гэж олон улсын болон бус нутгийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу Аюулгүйн зөвлөлөөс гаргасан шийдвэрээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын, эсхүл бус нутгийн холбогдох байгууллага, аливаа улсын удирдлага, зохион байгуулалтын дор явагдаж байгаа олон үндэстний нэгдсэн ажиллагааг;

3.1.2. “бие бүрэлдэхүүн” гэж энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор бэлтгэгдэж, томилогдсон цэрэг, цагдаагийн алба хаагчийг;

3.1.3.“цэрэг, цагдаагийн баг” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тогтоосон зохих бүтэц, орон тооны дагуу бие бүрэлдэхүүн болон бүх төрлийн зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, эд хэрэгслээр хангагдаж, тавигдсан үүргийг биелүүлэх чадавх бүхий энхийг дэмжих ажиллагаанд оролцооор томилогдсон нэгжийг;

3.1.4.“энхийг дэмжих ажиллагааны сургалт бэлтгэл” гэж олон улсын холбогдох байгууллага, аливаа улсын санаачилгаар зохион байгуулж байгаа тухайн энхийг дэмжих ажиллагаанд гүйцэтгэх үүргийн онцлог, тавигдах шаардлагыг хангахад чиглэсэн мэдлэг, дадлага, ур чадвар олгох, жигдрэлтийг хангах арга хэмжээний нэгдлийг.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ** **ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРӨЛЦӨГЧ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ**

#### **4 дүгээр зүйл. Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч**

4.1.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүн нь цэрэг, цагдаагийн алба хаагч, баг байна.

4.2.Энхийг дэмжих ажиллагаанд оролцооор томилогдсон бие бүрэлдэхүүн нь сайн дурын үндсэн дээр сонгогдож, тухайн ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлд бүрэн хамрагдсан байна.

4.3.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн алба хаагчийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, цагдаагийн алба хаагчийг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр тус тус томилно.

4.4.Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр томилогдсон цэрэг, цагдаагийн алба хаагчийг албан ажлын шаардлагыг харгалзан өөртэй нь тохиолцсоны дагуу энхийг дэмжих ажиллагаанаас ирэх хүртэлх хугацаанд эрх бүхий албан тушаалтан үндсэн албан тушаалаас нь өөр албан тушаалд шилжүүлэн томилж болно.

4.5.Энэ хуулийн 4.4-т заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан тухайн цэргийн алба хаагчид мэдэгдэж, саналыг бичгээр авна.

4.5.Цэрэг, цагдаагийн алба хаагч Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зарласан энгийн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцэж, үүрэг гүйцэтгэх тохиолдолд албанаас чөлөөлнө.

#### **5 дугаар зүйл. Энхийг дэмжих ажиллагаанд гүйцэтгэх үүрэг**

5.1.Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд дараах төрлийн үүрэг гүйцэтгүүлэхээр Зэвсэгт хүчний цэргийн баг, алба хаагчийг оролцуулна:

5.1.1.энгийн иргэнийг хамгаалах;

5.1.2.гал зогсоох гэрээний биелэлтэд хяналт тавих;

5.1.3.мөргөлдөгч талуудыг тусгаарлах, зэвсэг хураах;

- 5.1.4.зэвсэгт мөргөлдөөний хор уршгийг арилгах;
  - 5.1.5.инженерийн болон бүтээн байгуулалтын бусад ажил гүйцэтгэх;
  - 5.1.6.дурвэгсдийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;
  - 5.1.7.эмнэлгийн болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх;
  - 5.1.8.аюулгүй байдлыг хангах байгууллагын бие бүрэлдэхүүнийг сургах;
  - 5.1.9.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн мандатаар тогтоосон бусад үүрэг.
- 5.2.Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд дараах төрлийн үүрэг гүйцэтгүүлэхээр цагдаагийн баг, алба хаагчийг оролцуулна:
- 5.2.1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын бие бүрэлдэхүүн болон эд хөрөнгийг хамгаалах;
  - 5.2.2.энгийн иргэнийг хамгаалах;
  - 5.2.3.Нэгдсэн Үндэстний Байгууллагын цагдаагийн албаны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
  - 5.2.4.нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
  - 5.2.5. үүрэг гүйцэтгэх улсын цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, алба хаагчдыг сургаж бэлтгэх;
  - 5.2.6.хүмүүнлэгийн байгууллагын үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх;
  - 5.2.7.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн мандатаар тогтоосон бусад үүрэг.
- 5.3.Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч цэрэг, цагдаагийн алба хаагч, баг дараах нийтлэг үүргийг хүлээнэ:
- 5.3.1.Монгол Улсын хууль тогтоомж, Цэргийн нийтлэг дүрмүүд, Цагдаагийн албаны дүрэм, эрх бүхий байгууллага, цэрэг, цагдаагийн багийн захирагчийн тушаалаар тогтоосон журам, зааврыг дагаж мөрдөх;
  - 5.3.2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулагчийн болон өөрийн орны цэрэг, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлах;
  - 5.3.3.тухайн ажиллагаанд заагдсан үүргийн хүрээнд ахлах даргын тушаал, шийдвэрийг биелүүлэх, захирах, захирагдах ёсыг баримтлах;
  - 5.3.4.өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх;

5.3.5.үүрэг гүйцэтгэх улс, орны хууль тогтоомж, зан заншлыг хүндэтгэн дагаж мөрдөх, шашин шүтлэгт нь хүндэтгэлтэй хандах;

5.3.6.цагийн байдлын өөрчлөлт, үүрэг гүйцэтгэлтийн онцлогт нийцсэн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрхийн хязгаарлалтыг дагаж мөрдөх.

5.4.Энхийг дэмжих ажиллагаанд цэрэг, цагдаагийн багийг илгээнээр цэргийн баг, алба хаагч нь энхийг дэмжих ажиллагааны Цэргийн хүчний командлагчийн, цагдаагийн баг, цагдаагийн алба хаагч нь Цагдаагийн комиссарын ажиллагааны удирдлагад тус тус шилжинэ.

5.5.Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч болон цэрэг, цагдаагийн баг Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, журам, олон улсын гэрээг зөрчсөн, сахилгын ноцтой зөрчил гаргасан, гэмт хэрэгт холбогдон хугацаанаас өмнө эгүүлэн татагдах тохиолдолд түүнтэй холбогдон гарах зардлыг тухайн алба хаагч өөрөө хариуцна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх**

6.1.Монгол Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрх зүйн үндсийг тогтоох;

6.1.2.энэ хуулийн 7.1.3-т заасан зардлыг жил бүрийн төсөвт тусгах .

### **7 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх**

7.1.Монгол Улсын Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн цэрэг, цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах, эгүүлэн татах шийдвэр гаргах;

7.1.2.энхийг дэмжих ажиллагаанд оролцох асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, бус нутгийн холбогдох байгууллага, бусад улстай гэрээ, хэлэлцээр байгуулах;

7.1.3.энхийг дэмжих ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын чадавхыг бүрдүүлэх болон шаардлагатай зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган, цэрэг, цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах;

7.1.4.энхийг дэмжих ажиллагааны сургалт, бэлтгэлийг өөрийн оронд зохион байгуулах, гадаад улсад энэ төрлийн арга хэмжээнд бие бүрэлдэхүүнийг оролцуулах шийдвэр гаргах;

7.1.5.Монгол Улсаас хилийн чанадад энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэлд оролцохоор томилогдсон бие бүрэлдэхүүн болон өөрийн оронд зохион байгуулах энэ төрлийн сургалт, бэлтгэлд оролцох гадаад орны бие бүрэлдэхүүн,

тэдгээрийн зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, эд хэрэгсэлд хил, гаалийн шалгалт хийх, навигацийн болон бусад үйлчилгээний журмыг тогтоох;

7.1.6.Нэгдсэн Үндэстний Байгууллагаас олгосон нөхөн төлбөрөөс энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд олгох томилолтын зардал болон Зэвсэгт хүчний болон Цагдаагийн хөгжлийн санд төвлөрүүлэх хувь хэмжээг тогтоох;

7.1.7.энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлыг санхүүжүүлэх журмыг тогтоох.

## **8 дугаар зүйл. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

8.1.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.Монгол Улсаас оролцох боломжтой энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэл, тусlamж, дэмжлэгийн асуудлыг Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран судалж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

8.1.2.Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаа, энэ талаархи сургалт, бэлтгэлд оролцуулах болон хангарт, үйлчилгээтэй холбогдсон асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, холбогдох улс, бус нутгийн байгууллагатай харилцаж, зохицуулах;

8.1.3.энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэлд оролцож байгаа бие бүрэлдэхүүний эрхийг хамгаалах;

8.1.4.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомж, Нэгдсэн Үндэстний Байгууллага, олон улсын гэрээгээр тогтоосон дүрэм, журам зөрчсөн, сахилгын ноцтой зөрчил гаргасан, амь насаа алдсан, шархадсан, ар гэрийн, эсхүл эрүүл мэндийн байдлаас шалтгаалан үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд эх оронд нь эгүүлэн татах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

## **9 дүгээр зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

9.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.зэвсэгт хүчний цэргийн багийг энхийг дэмжих ажиллагаа, эсхүл сургалт бэлтгэлд оролцуулах асуудлыг Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

9.1.2.цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын сонгож санал болгосноор энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүнийг томилох, хугацааг сунгах, эгүүлэн татах, ажиллагааны үүрэг гүйцэтгэлтийг дуусгавар болгох шийдвэр гаргах;

9.1.3.энэ хуулийн 8.1.4-т заасан шалтгааны улмаас алба хаагч, цэргийн багийг эгүүлэн татах ажлыг зохион байгуулах;

9.1.4.цэргийн баг, цэргийн алба хаагчийг энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэлийг хангуулах асуудлыг боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.5.Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа байдлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газарт мэдээлэх;

9.1.6.энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийг энэ хуулийн 7.1.7-д заасан хувь хэмжээг баримтлан захиран зарцуулах;

9.1.7.энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах, сургаж бэлтгэх, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журмыг батлах;

9.1.8.энэ хуулийн 8.1.4-т заасны дагуу эгүүлэн татах үед дараагийн цэргийн алба хаагчаар нөхөн хангах эсэх асуудлыг шийдвэрлэх;

9.1.9.энэ хуулийн 7.1.7-д заасан хувь хэмжээг тогтоох саналыг боловсруулж, Засгийн газраар шийдвэрлүүлэх;

9.1.10.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд томилолтын зардал олгох журмыг батлах;

9.1.11.энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журмыг батлах.

## **10 дугаар зүйл. Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

10.1.Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаа, эсхүл сургалт бэлтгэлд оролцуулах асуудлыг Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

10.1.2.цагдаагийн төв байгууллагаас сонгож санал болгосноор энхийг дэмжих ажиллагаа, сургалт бэлтгэлд оролцуулах цагдаагийн алба хаагч, багийг томилох, хугацааг сунгах, эгүүлэн татах, ажиллагааны үүрэг гүйцэтгэлтийг дуусгавар болгох шийдвэр гаргах;

10.1.3.энэ хуулийн 8.1.4-т заасан шалтгааны улмаас цагдаагийн алба хаагч, цагдаагийн багийг эгүүлэн татах;

10.1.4.энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийг энэ хуулийн 7.1.7-д заасан хувь хэмжээг баримтлан захиран зарцуулах;

10.1.5.цагдаагийн баг, цагдаагийн алба хаагчийг энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэлийг хангуулах асуудлыг боловсруулж хэрэгжүүлэх;

10.1.6.энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах цагдаагийн баг, бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журмыг батлах.

10.1.7.энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журмыг батлах.

## **11 дүгээр зүйл. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын бүрэн эрх**

11.1.Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагч, цэргийн багийн ажиллагааны өмнөх бэлтгэлийг хангах;

11.1.2.энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа цэргийн алба хаагч, цэргийн багийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавих;

11.1.3.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчтай гэрээ байгуулах, дүгнэх, түүний биелэлтэд хяналт тавих;

11.1.4.энхийг дэмжих ажиллагаанд шинээр оролцуулах цэргийн багийг Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлэх, бэлтгэлийг хангах, илгээх асуудлыг холбогдох байгууллагад уламжлах;

11.1.5.тухайн газар орны хариуцлагын бүс дэх нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан цэргийн алба хаагч, цэргийн багийн аюулгүй байдалд ноцтой аюул, заналхийлэл учирсан тохиолдолд тухайн ажиллагааны дээд штабтай харилцан ажиллаж, эрх бүхий албан тушаалтан, байгууллагыг мэдээллээр хангах, санал танилцуулах;

11.1.6.цэргийн алба хаагч, цэргийн багийн үүрэг гүйцэтгэлт, ажиллагааны цагийн байдлын талаар хагас жил тутам, шаардлагатай үед Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тухай бүр мэдээллэх;

11.1.7.цэргийн алба хаагч, цэргийн багийн үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах саналыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах;

11.1.8.энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах ажлыг зохион байгуулах;

11.1.9.энхийг дэмжих ажиллагааны туршлага, сургамжийг судлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох.

## **12 дугаар зүйл. Цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх**

12.1.Цагдаагийн төв байгууллагын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.цагдаагийн алба хаагч, багийн энхийг дэмжих ажиллагааны болон сонгон шалгаруулалтын өмнөх сургалт бэлтгэлийг зохион байгуулах;

12.1.2.цагдаагийн алба хаагч, багийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавих;

12.1.3.энхийг дэмжих ажиллагаанд шинээр оролцуулах цагдаагийн багийг бэлтгэх үед Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлэх, бэлтгэлийг хангах, илгээх асуудлыг холбогдох байгууллагад уламжлах;

12.1.4.цагдаагийн алба хаагч, багийн үүрэг гүйцэтгэлт, ажиллагааны цагийн байдлын талаар хагас жил тутам, шаардлагатай үед хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тухай бүр мэдээлэх;

12.1.5.цагдаагийн алба хаагчийг энхийг дэмжих ажиллагаанд нэр дэвшүүлэх, үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах, эгүүлэн татах саналыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж, шийдвэрлүүлэх;

12.1.6.энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялdryг нөхөн сэргээх, сувилах ажлыг зохион байгуулах.

### **13 дугаар зүйл. Цэрэг, цагдаагийн багийн захирагчийн нийтлэг эрх, үүрэг**

13.1.Цэрэг, цагдаагийн багийн захирагч тактикийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

13.2.Цэрэг, цагдаагийн багийн захирагч нь тухайн багт нэгдмэл удирдлага, нэгтгэн захирах ёсыг хэрэгжүүлэгч, нийт бие бүрэлдэхүүний шууд захирах дарга бөгөөд дараах нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

13.2.1.сонгон шалгаруулалтад тэнцсэн бие бүрэлдэхүүний ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлийг удирдан явуулах;

13.2.2.цэрэг, цагдаагийн алба хаагчийн эрүүл мэнд, бие бялдар, ёс зүй, сахилга бат, нас, ажилласан жил, цол, ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлийн үр дүнг үндэслэн албан тушаалд томилох, чөлөөлөх санал гаргах;

13.2.3.Монгол Улсын хууль тогтоомж, Цэргийн нийтлэг дүрмүүд, Цагдаагийн албаны дүрэм, Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх зүйн баримт бичгүүдэд нийцүүлэн холбогдох тушаал, шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангах;

13.2.4.цэрэг, цагдаагийн багийн хэмжээнд цэргийн алба, цагдаагийн үйл ажиллагаа, сургалт бэлтгэл, бэлэн байдлыг хангах, үүрэг гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах, удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

13.2.5.бие бүрэлдэхүүний ажиллагааны үүрэг гүйцэтгэлт, сахилга хариуцлага, мэдлэг, үр чадвар, ажлын туршлагыг харгалзан алба хаагчийг холбогдох албан тушаалд сэлгэн ажиллуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд гаргах;

13.2.6. бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг удирдан зохион байгуулах;

13.2.7. энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн байдал, үр дүнг үнэлж Нэгдсэн Үндэстний Байгууллагын, эсхүл бусад байгууллагын шагнал, Монгол Улсын төрийн одон, медаль, салбарын шагналаар алба хаагчийг шагнуулах саналыг холбогдох байгууллагад уламжлах;

13.2.8. энхийг дэмжих ажиллагаанд оролцсон туршлага, сургамжийн талаар санал, зөвлөмж боловсруулж, цэргийн мэргэжлийн дээд удирдлагын, эсхүл цагдаагийн төв байгууллагын удирдлагад танилцуулах.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **14 дүгээр зүйл. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний эрх зүйн байдал**

14.1. Энхийг дэмжих ажиллагаанд оролцооор томилогдсон бие бүрэлдэхүүний эрх зүйн байдал нь уг ажиллагааг зохион байгуулахтай холбогдуулан эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр болон Нэгдсэн Үндэстний Байгууллага, бус нутгийн байгууллага, тухайн ажиллагаа явагдаж байгаа улстай байгуулсан гэрээгээр тодорхойлогдоно.

14.2. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүн тухайн ажиллагааг удирдахаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, бус нутгийн байгууллага, аливаа улсын шийдвэрээр байгууллагдсан олон үндэстний цэргийн хүчний командлал, цагдаагийн комиссарын удирдлагад захирагдах бөгөөд энэ нь бие бүрэлдэхүүн энхийг дэмжих тухайн ажиллагааны бүсэд байх хугацаанд хамаарна.

14.3. Бие бүрэлдэхүүн нь цэрэг, цагдаагийн дүрэмт хувцас, цолны болон ялгах тэмдэгтэй байх бөгөөд тухайн ажиллагааг удирдаж байгаа эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрээр тусгай таних тэмдэг хэрэглэж болно.

15.4. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хугацаанд цэрэг, цагдаагийн алба хаагчийн албан тушаалыг хэвээр хадгалж, өөрөө зөвшөөрсэн тохиолдолд цалин хөлсийг итгэмжлэгдсэн этгээдэд олгож болно.

14.5. Бие бүрэлдэхүүнээс энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед амь насаа алдсан, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

14.6. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед алба хаагч хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан тохиолдолд Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох комиссын дүгнэлтийг харгалзан нөхөн олговор олгуулах эсэх асуудлыг судлан шийдвэрлүүлэхэд цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага, эсхүл цагдаагийн төв байгууллагаас дэмжлэг үзүүлнэ.

14.7. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэрэг, цагдаагийн алба хаагч ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй тохиолдолд холбогдох хуульд заасан мөнгөн урамшуулал олгоно.

14.8. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд заавал хамруулсан байх бөгөөд даатгалтай холбогдон гарах зардлыг тухайн ажиллагааг удирдаж байгаа эрх бүхий байгууллага, аливаа улстай байгуулсан хоёр талын, эсхүл олон талт олон улсын гэрээнд тусгаагүй бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

14.9. Цэрэг, цагдаагийн алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

## **15 дугаар зүйл. Энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбогдох зардал**

15.1. Энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбогдох зардал нь сургалт бэлтгэл, хангарт, сонгон шалгаруулалт, оролцох үеийн зардлаас бүрдэх бөгөөд уг зардлыг жил бүрийн улсын төсвийн Батлан хамгаалахын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын арга хэмжээний зардалд тусгасан байна.

15.2. Энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа бие бүрэлдэхүүний цалин хөлс, хангамж, эдийн засгийн бусад баталгааг төр хариуцна.

## **16 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

16.1. Энэ хуулийг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## **17 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

17.1. Энэ хуулийг 2024 оны .. дугаар сарын ..-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг